



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Автомашины тоо, төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашины ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;


2.2. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001454

15-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 05 дугаар сарын 29 ны/ний өдрийн
059 дугаар тогтоолын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДОТООД АЛБАН АЖЛЫН
ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин (туулах чадвар сайтай)	2
2		Хот доторх ажлын суудлын автомашин (жижиг)	1
3		Ажлын жижиг оврын автобус (микро автобус)	2
Нийт автомашин			5